



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР

Жуулчны гудамж 5, 4 дүгээр хороо,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 264152, Факс: (976-11) 326611
Цахим шуудан: info@namem.gov.mn
Цахим хуудас: <http://namem.gov.mn/>

2026.05.21 № 01/400

танай _____-ны № _____-т

Г ХАРЬЯА БАЙГУУЛЛАГЫН ДАРГА, Г
ЗАХИРАЛ НАРТ

Г Зөвлөмж хүргүүлэх тухай Г

Харьяа байгууллагуудын 2026 оны 1 дүгээр улирлын “Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай” хуулийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн танилцуулга зөвлөмжийг хүргүүлж байна.

Нээлттэй мэдээллийн “shilen.gov.mn” системд 2026 оны хагас жилийн мэдээг үнэн зөв, бүрэн оруулж 06 дугаар сарын 20-ны өдрийн дотор зөвлөмжийн биелэлтийг ирүүлнэ үү.

Хавсралт 7 хуудастай.



Цаг уур орчны шинжилгээний газар
Удирдлага
Дарга
Эрхэмбаяр Баттулга
2026-05-21 18:03:26

ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА

2026 оны 05 дугаар сарын 20

Улаанбаатар хот

Нэг. Хяналт шинжилгээ хийх үндэслэл

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Засгийн газрын 2026 оны 41 дүгээр тогтоолоор шинэчлэн батлагдсан “Цахим хуудас хөтлөх, ил тод, нээлттэй мэдээллийг цахим хэлбэрээр байршуулж нийтлэх, шинэчлэх, хяналт тавих нийтлэг журам”, “Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам”-ын хэрэгжилтийн байдалд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийв.

Хоёр. Ажлын хамрах хүрээ, бүрэлдэхүүн

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-8.6-д заасан нээлттэй мэдээллийг шинэчлэгдсэн журмын дагуу төрийн байгууллагын нэгдсэн цахим хуудас болон Нээлттэй мэдээллийн “shilen.gov.mn” системд салбарын 25 байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбар, олон нийтэд түгээсэн мэдээ, тайлан мэдээллийг үнэн зөв, бүрэн оруулсан эсэхэд Хяналт, шинжилгээ дотоод аудитын хэлтсийн дотоод хяналт хариуцсан ахлах мэргэжилтэн С.Наранчимэг 2026 оны 05 дугаар сарын 06-аас 05 дугаар сарын 20-ны өдрийн хооронд ажиллав.

Гурав. Мэдээлэл байршуулах хууль эрх зүйн орчин

3.1 Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлд нийтийн мэдээлэл хариуцагч төрийн байгууллага байх бөгөөд хуульд заасан чиг үүргийнхээ хүрээнд нийтийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглах, удирдлага, зохион байгуулалт, мэдээллийн аюулгүй байдлыг хангах, шаардлагатай бусад арга хэмжээ авах үүрэгтэй гэж заасан.

Нийтийн мэдээлэл хариуцагч төрийн байгууллага нь нээлттэй мэдээллийг тогтмол хугацаандаа шинэчлэн хуулийн 8.1-д “Төрийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах, төрийн үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох зорилгоор мэдээлэл хариуцагчийн чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалт, хүний нөөц, төсөв санхүү, худалдан авах ажиллагаа, үзүүлж байгаа үйлчилгээ болон хуулиар хаалттай, хязгаарлалттай гэж тогтоосноос бусад мэдээллийг ил тод, нээлттэй байлгана” гэсний дагуу эдгээр мэдээллийг хуулийн 8.2-оос 8.6-д заасан зүйл заалт бүрээр өөрийн байгууллагат хамаарал бүхий мэдээллийг байгууллагын цахим хуудас болон нээлттэй өгөгдлийн нэгдсэн системд нийтлэн, шинэчилнэ.

Хуулийн 8.8-д Мэдээлэл хариуцагч энэ хуулийн 8.2, 8.3, 8.4, 8.5, 8.6-д заасан байнга ил тод нээлттэй байлгах мэдээллийг олон нийтэд хүргэхдээ цахим хуудас, мэдээллийн самбар, мэдээллийн бусад хэрэгсэл ашиглана.

Хуулийн 8.9-д Хуульд өөрөөр заагаагүй бол мэдээлэл хариуцагч энэ хуулийн 8.2, 8.3, 8.4, 8.5, 8.6-д заасан тайлан, мэдээ, үр дүн, статистик мэдээллийг улирал, хагас жил, жилээр гаргах бөгөөд дараагийн улирал, хагас жил, жилийн эхний сард багтаан бүрэн бүтэн, үнэн зөв байдлыг хангаж цахим хуудсандаа болон нээлттэй мэдээллийн системд байршуулна.

Хуулийн 8.11-д Мэдээлэлд өөрчлөлт оруулсан бол өөрчлөлт оруулснаас хойш ажлын гурван өдрийн дотор өөрчлөлтийг тусгаж, мэдээллийг шинэчлэн нийтэлнэ” гэж тус тус заасныг баримтлан ажиллана.

3.2 Засгийн газрын 2026 оны 02 дугаар сарын 04-ны өдрийн 41 дүгээр тогтоол

Засгийн газрын 41 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтаар “Цахим хуудас хөтлөх, ил тод, нээлттэй мэдээллийг цахим хэлбэрээр байршуулж нийтлэх, шинэчлэх, хяналт тавих

нийтлэг журам”, хоёрдугаар хавсралтаар “Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам”-ыг шинэчлэн баталсан.

“Цахим хуудас хөтлөх, ил тод, нээлттэй мэдээллийг цахим хэлбэрээр байршуулж нийтлэх, шинэчлэх, хяналт тавих нийтлэг журам”-ын 1.2-т Мэдээлэл хариуцагч нь хууль болон энэ журам, Монгол Улсын стандарт “Төрийн байгууллагын веб сайтад тавих шаардлага MNS 6285”-д нийцүүлэн нээлттэй мэдээллийг цахим хуудсанд байршуулж нийтлэх, шинэчлэх, хяналт тавих талаар дотоод журам батлан мөрдүүлж болно.

Журмын 2.4-т “Байгууллагын админ” болон “Байгууллагын бусад хэрэглэгч”-ийн хандах эрх нь Мэдээлэл хариуцагчид байх бөгөөд дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

- байгууллагын админ болон байгууллагын бусад хэрэглэгчийн хандах эрх хариуцах ажилтныг томилох;

- байгууллагын админы эрх бүхий албан хаагчийн бүртгэлд өөрчлөлт орсон тухай бүрд Агентлагт мэдэгдэж, тохиргоо хийлгэх;

- өөрийн байгууллага, харьяа, салбар байгууллагын холбогдох хэрэглэгчдэд цахим хуудасны үйл ажиллагаа, ашиглалтын талаар зөвлөгөө, мэдээлэл өгөх, сургалт зохион байгуулах, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх;

- байгууллагын админ нь өөрийн байгууллагын бусад хэрэглэгчийн хандах эрхийг, харьяа, салбарын хэмжээнд байгууллагын админы хандах эрхийг удирдах, эрх авсан албан хаагчийн бүртгэлд өөрчлөлт орох бүрд шинэчлэн тохируулах;

- байгууллагын админ нь цахим хуудсанд системийн үндсэн боломжийн хүрээнд 3 хүртэлх цэсийг байгууллагын цэсэд үүсгэх эрхтэй байх бөгөөд энэ нь цахим хуудас дахь цэс болон мэдээлэлтэй давхардахгүй, мэдээллүүдийг баяжуулах, бусад төрлийн системүүдтэй холбох, тохиргоо хийх;

- байгууллагын админ нь цахим хуудасны ашиглалт, хэвийн үйл ажиллагаа, түүний сайжруулалттай холбоотой санал, хүсэлтийг харьяа байгууллагын хэмжээнд нэгтгэн Агентлагт хүргүүлэх;

- байгууллагын админ нь цахим хуудсанд техникийн алдаа, аюулгүй байдлын эрсдэл саатал гарсан тохиолдолд шалтгааныг даруй тодруулж Академид мэдэгдэн, шаардлагатай арга хэмжээг авах;

- байгууллагын бусад хэрэглэгч нь цахим хуудсанд өөрийн байгууллагын мэдээ, мэдээллийг тогтмол шинэчлэн нийтэлж, үнэн зөв байдлыг хариуцах;

- байгууллагын бусад хэрэглэгч нь цахим хуудасны ашиглалт сайжруулалттай холбоотой саналыг байгууллагын админд хүргүүлэх.

“Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам”-ын дагуу Нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээ хийх аргачлал нь дараах байдалтай байна.

- Мэдээллийн хүртээмжтэй байдал (МХБ) - Нийтийн ил тод байдлын тухай хуулийн 8.8-д заасны дагуу нээлттэй мэдээллийг цахим хуудас, мэдээллийн самбар, бусад мэдээллийн хэрэгсэл ашиглан нийтэлсэн бол хангалттай буюу 30 оноо, нээлттэй мэдээллийг дутуу буюу зөвхөн цахим хуудаст нийтэлсэн бол 15 оноо, мэдээллийн самбарт нийтэлсэн бол 10 оноо, бусад мэдээллийн хэрэгсэл ашиглан нийтэлсэн бол 5 оноо, нээлттэй мэдээллийг нийтлээгүй бол хангалтгүй буюу 0 оноо;

- Хугацаандаа нийтлэгдсэн байдал (ХНБ) - нээлттэй мэдээллийг Нийтийн ил тод байдлын тухай хуулийн 8.9, 8.11-д -д заасан хугацаанд олон нийтэд хүргэсэн эсэх, нээлттэй мэдээллийг хуулиар тогтоосон хугацаанд нийтэлсэн, шинэчилсэн бол хангалттай буюу 30 оноо, нээлттэй мэдээллийг хуулиар тогтоосон хугацаанаас хойш нийтэлсэн, шинэчилсэн бол дутуу буюу 10 оноо, улирал бүр шинэчлэгддэг нээлттэй мэдээллийг нийтлээгүй, шинэчлээгүй бол хангалтгүй буюу 0 оноо;

- Хуулийн 8 дугаар зүйлийн 8.2.1, 8.2.2, 8.3.3, 8.3.6-д заасан цахим хуудсанд байршсан, шалгуур хангасан, байнга шинэчлэгддэггүй мэдээллийн оноог бүрэн тооцно.

- Мэдээллийн бүрэн бүтэн байдал (МБББ) – хуулиар 8.6-д заасан мэдээллийг ил тод байлгах үүрэг хүлээгээгүй мэдээлэл хариуцагчийн хувьд хуулийн 8.2, 8.3, 8.4, 8.5-д заасан нээлттэй мэдээллийг бүрэн гүйцэд нийтэлсэн бол 30 оноо, дутуу нийтэлсэн бол 15 оноо, хуулиар 8.6-д заасан мэдээллийг ил тод байлгах үүрэг хүлээгээгүй мэдээлэл хариуцагчийн хувьд хуулийн 8.2, 8.3, 8.4, 8.5-д заасан нээлттэй мэдээллийг бүрэн гүйцэд нийтэлсэн бол 15 оноо, дутуу нийтэлсэн бол 10 оноо; хуулийн 8.6-д заасан нээлттэй мэдээллийг бүрэн гүйцэд нийтэлсэн бол 15 оноо дутуу нийтэлсэн бол 5 оноо, хуулийн 8.2, 8.3, 8.4, 8.5, 8.6-д заасан нээлттэй мэдээллийг нийтлээгүй бол 0 оноо;

- Эх сурвалжийн тодорхой байдал (ЭСТБ) – нээлттэй мэдээллийг дэлгэрүүлж авах, тодруулах эрх бүхий ажилтны харьяалах нэгжийн нэр, албан тушаал, нэр болон холбоо барих мэдээллийг нийтэлсэн бол хангалттай буюу 30 оноо; аль нэгийг нийтлээгүй бол дутуу буюу 10 оноо, мэдээллийг нийтлээгүй бол хангалтгүй буюу 0 оноо гэж дүгнэдэг.

Мэдээлэл хариуцагч цахим хуудас болон нээлттэй мэдээллийн нэгдсэн системд байршуулсан мэдээллийн үнэн зөв, алдаагүй байдлыг хариуцна.

Нээлттэй мэдээллийг холбогдох журмын дагуу хугацаанд нь ил тод байршуулаагүй байгууллага албан тушаалтанд Төрийн албаны тухай хууль, Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ гэж заасан байна.

Дөрөв. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Засгийн газрын 2026 оны 41 дүгээр тогтоолоор шинэчлэн батлагдсан “Цахим хуудас хөтлөх, ил тод, нээлттэй мэдээллийг цахим хэлбэрээр байршуулж нийтлэх, шинэчлэх, хяналт тавих нийтлэг журам”, “Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам”-ын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, үнэлгээг нэгтгэсэн.

Ус цаг уур, орчны шинжилгээний салбарын байгууллагуудын 2026 оны 1 дүгээр улирлын мэдээ мэдээллийг төрийн байгууллагын нэгдсэн цахим хуудас болон Нээлттэй мэдээллийн (shilen.gov.mn) системд 5 бүлэг 87 асуудлаар бэлтгэн холбоос, файл, ил тодын самбарт байршуулсан байдал, шалгуур үзүүлэлтийн оноо хасагдсан шалтгаан зэргийг байгууллага, бүлэг, асуудал бүрээр нягтлан шалгав. Үүнд:

1. Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдалд нийт 18 мэдээлэл байна. Үүнээс өөрийн байгууллагат хамаарал бүхий мэдээллийг цахим хуудастай холбож тухайн мэдээллийн файлыг .pdf болгон оруулаад ил тодын самбарын зургийг бүтнээр оруулж өгнө. Тухайн байгууллагат холбоо хамааралгүй мэдээллийн хуулийн заалт үндэслэлийг заавал бичиж оруулна.

2. Хүний нөөцийн талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдалд нийт 7 мэдээлэл байгаа үүнийг бүх байгууллага заавал оруулах бөгөөд мэдээллийг цахим хуудастай холбож тухайн мэдээллийн файлыг .pdf болгон оруулаад ил тодын самбарын зургийг бүтнээр оруулж өгнө.

3. Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдалд нийт 29 мэдээлэл байна. Үүнээс төсөв, санхүүгийн хамааралтай мэдээллийг цахим хуудас болон шилэн данстай холбож тухайн мэдээллийн файлыг .pdf болгон оруулаад ил тодын самбарын зургийг бүтнээр оруулж өгнө. Тухайн байгууллагат холбоо хамааралгүй мэдээллийн хуулийн заалт үндэслэлийг заавал бичиж оруулна.

4. Үзүүлж байгаа үйлчилгээний талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдалд нийт 6 мэдээлэл багтах бөгөөд эхний 3 мэдээллийг цахим хуудастай холбож тухайн мэдээллийн файлыг .pdf болгон оруулаад ил тодын самбарын зургийг бүтнээр оруулж өгнө. Бусад мэдээллийн холбоо хамааралгүй болох тухай хуулийн заалт үндэслэлийг заавал бичиж оруулна.

5. Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдалд нийт 27 мэдээлэл байна. Үүнээс өөрийн байгууллагат хамаарал бүхий мэдээллийг цахим хуудастай холбож тухайн мэдээллийн файлыг .pdf болгон оруулаад ил тодын самбарын зургийг бүтнээр оруулж өгнө. Тухайн

байгууллагат холбоо хамааралгүй мэдээллийн хуулийн заалт үндэслэлийг заавал бичиж оруулна.

2026 оны 1 дүгээр улиралд Нээлттэй мэдээллийн системд салбарын байгууллагууд мэдээ, мэдээллээ хугацаанд оруулан Шилэн индексэд баталгаажсан үнэлгээ авсан байдлаас үзэхэд 17 байгууллага 80%-аас дээш, 61-79%-тай 6 байгууллага, Хэнтий аймгийн УЦУОШТ 48%, Нислэгийн цаг уурын төв 34%-тай үнэлэгдсэн. Өмнөговь аймгийн УЦУОШТ-өөс 1 дүгээр улирлын нээлттэй мэдээллийг хугацаанд нь байршуулаагүй байна.

Салбарын хэмжээнд Нээлттэй мэдээллийн системд орсон мэдээ мэдээллийг түгээх үйл ажиллагааны зохион байгуулалт, хүртээмж, хуульд нийцсэн байдал зэргийн үнэлгээ дунджаар 81 хувийн биелэлттэй дүгнэгдсэн байна (Хүснэгт 1).

Хүснэгт 1.

Нээлттэй мэдээллийн ил тод байдлын ЦУОШГ, харьяа байгууллагуудын үнэлгээ /%/

Д/д	Байгууллагын нэр	2025 оны I улирал	2026 оны I улирал	Нийтлэг алдаа
1	Хөвсгөл УЦУОШТ	51	100	эх сурвалжийг журмын дагуу бичих
2	Ховд УЦУОШТ	0	99	эх сурвалжийг журмын дагуу бичих
3	Дундговь УЦУОШТ	96	99	ил тодын самбарын зураг бүтнээр оруулах
4	Говьсүмбэр УЦУОШТ	83	99	эх сурвалж бичих, самбарын зураг оруулах
5	Сүхбаатар УЦУОШТ	98	98	зарим файл оруулаагүй, эх сурвалж бичих
6	Архангай УЦУОШТ	30	97	холбоос, файл буруу, эх сурвалж бичих
7	Цаг уур, орчны шинжилгээний газар	0	97	холбоос буруу, файлын мэдээлэл зөрсөн
8	Орхон УЦУОШТ	0	96	холбоос буруу, файлд эх сурвалж дагуу бичих
9	Дорноговь УЦУОШТ	90	95	нээлттэй байршуулаагүй-1, эх сурвалж бичих
10	Увс УЦУОШТ	0	96	эх сурвалжийг журмын дагуу бичих
11	Булган УЦУОШТ	0	93	нээлттэй байршуулаагүй-1, холбоос зөв хийх, эх сурвалжийг журмын дагуу бичих
12	Баян-Өлгий УЦУОШТ	0	93	шилэн данс шууд холбох, эх сурвалж бичих
13	Өвөрхангай УЦУОШТ	0	90	нээлттэй байршуулаагүй-1, холбоос файл зөрөөтэй, эх сурвалжийг журмын дагуу бичих
14	Завхан УЦУОШТ	72	90	эх сурвалж бичих, самбарын зураг оруулах
15	Говь-Алтай УЦУОШТ	0	89	холбоос буруу, эх сурвалж бичих, ил тодын самбарын зураг бүтнээр оруулах
16	Дархан-Уул УЦУОШТ	65	86	холбоосгүй, эх сурвалж бичих, ил тодын самбарын зураг бүтнээр оруулах
17	Ус цаг уур, орчны судалгаа мэдээллийн хүрээлэн	0	83	зарим мэдээ дутуу, холбоос буруу, эх сурвалжийг журмын дагуу бичих
18	Улаанбаатар УЦУОШТ	0	79	холбоос, файл буруу, эх сурвалж бичих
19	Байгаль орчин, хэмжил зүйн төв лаборатори	0	77	холбоос буруу, эх сурвалжийг журмын дагуу бичих, ил тодын самбарын зураг бүтнээр оруулах
20	Төв УЦУОШТ	0	77	нээлттэй байршуулаагүй-1, холбоос буруу, файл, зураг оруулах
21	Сэлэнгэ УЦУОШТ	97	74	нээлттэй байршуулаагүй-2, нэг мэдээг олон дахин оруулсан, эх сурвалж бичих
22	Баянхонгор УЦУОШТ	0	61	шилэн данс шууд холбох, эх сурвалж бичих
23	Дорнод УЦУОШТ	0	61	нээлттэй байршуулаагүй-1, холбоос хийх, санхүүд газрын данс бичсэн, эх сурвалж бичих
24	Хэнтий УЦУОШТ	50	48	нээлттэй байршуулаагүй-5, холбоос зөв хийх, эх сурвалж бичих
25	Нислэгийн цаг уурын төв	0	34	нээлттэй байршуулаагүй-7, холбоос хийх, эх сурвалж бичих, зураг оруулах
26	Өмнөговь УЦУОШТ	0	0	нээлттэй мэдээлэл хугацаандаа байршуулаагүй
Салбарын дундаж хувь		28	81	

Байгууллага бүр өөрт холбоо хамраалгүй мэдээ мэдээллийн талаар дэлгэрэнгүй тайлбарыг хуулийн зүйл заалт, үндэслэлтэй бичих ёстой бөгөөд оруулаагүй тохиолдолд нээлттэй мэдээллийг нийтлээгүй гэж үзнэ. Нислэгийн цаг уур 7, Булган аймгийн УЦУОШТөв 1, Дорноговь аймгийн УЦУОШТөв 1, Дорнод аймгийн УЦУОШТөв 1, Өвөрхангай аймгийн УЦУОШТөв 1, Сэлэнгэ аймгийн УЦУОШТөв 2, Төв аймгийн УЦУОШТөв 1, Хэнтий аймгийн УЦУОШТ 5 удаа нээлттэй байршуулаагүй 0 оноо буюу хангалтгүй үнэлгээ авсан байна.

Нээлттэй мэдээллийн ил тод байдлыг дараах 4 шалгуур үзүүлэлтээр асуудал тус бүрээр 30 хүртэл оноогоор үнэлж хэрэгжилтийн хувийг гаргадаг. Үүнд:

1. Мэдээллийн хүртээмжтэй байдал (МХБ). Нээлттэй мэдээллийг цахим хуудас, мэдээллийн самбар, бусад мэдээллийн хэрэгсэл ашиглан нийтэлсэн байх. Байгууллагын эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл, тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүнг бүрэн дүүрэн тусгаагүй, хүний нөөцийн стратеги, төлөвлөлт түүний хэрэгжилтийг хянаж үнэлэх журам, албан хаагч, ажилтныг сонгон шалгаруулах журам, албан тушаалын тодорхойлолт дутуу, өмнөх оны төсвийн гүйцэтгэл, тухай жилийн төсөв, дараа оны төсвийн төсөл, худалдан авах ажиллагааны баримт бичиг, үйлчилгээний нэр төрөл, үйлчилгээний хөлс, төлбөр төлөх дансны мэдээлэл бүрэн оруулах;

2. Хугацаандаа нийтлэгдсэн байдал (ХНБ). Нээлттэй мэдээллийг хуулиар тогтоосон хугацаанд нийтэлсэн, шинэчилсэн байх. Цахим хуудасны мэдээллийг тухай бүр шинэчлээгүй. Өөрийн байгууллагат хамаарал бүхий мэдээллийг төрийн байгууллагын нэгдсэн цахим хуудас, байгууллагын цахим хуудас болон нээлттэй өгөгдлийн нэгдсэн системд улирал бүр өөрчлөлт, шинэчлэлтийг тогтмол хийгээгүй. Бүтцийн өөрчлөлтийн зарим мэдээлэл, ажлын байрны сул орон тоо, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх мэдээ, тендерийн баримт бичиг, төсвийн гүйцэтгэлийн биелэлт болон хагас, бүтэн жилийн санхүүгийн тайлан, төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, хэрэгжилт, явц, үр дүнгийн талаар мэдээллийг шинэчлэн хугацаандаа хийх;

3. Мэдээллийн бүрэн бүтэн байдал (МБББ). Хуулийн 8.6-д заасан мэдээллийг ил тод байлгах үүрэг хүлээгээгүй мэдээлэл хариуцагчийн хувьд хуулийн 8.2, 8.3, 8.4, 8.5-д заасан нээлттэй мэдээллийг бүрэн гүйцэд нийтэлсэн байх. Тухайн мэдээллийн зөв линкийг холбох, тухайн мэдээллийн pdf файлыг оруулах, байгууллагын мэдээллийн самбарт байршуулсан зураг зэргийг бүх мэдээлэлд оруулах;

4. Эх сурвалжийн тодорхой байдал (ЭСТБ). Нээлттэй мэдээллийг дэлгэрүүлэн тодруулах ажилтны харьяалах нэгжийн нэр, албан тушаал, нэр болон холбоо барих мэдээллийг холбоос хийсэн цахим хуудас, файл дээр оновчтой байрлуулах, "Ил тод байдал" гэсэн тусгай цэс үүсгэсэн ч хуульд заасан шаардлагатай мэдээллийг нэг дор төвлөрүүлнэ. Хэрэглэгчдэд ойлгомжтой, хялбар хайлт хийх боломжтой байхаар зохион байгуулж мэдээлэлд холбогдох ажилтны нэр, цахим шуудан, эх сурвалжийг тодорхой бичиж оруулаагүй байна.

Хүснэгт 2.

2026 оны 1 дүгээр улирал "Нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээ"-ын шалгуур үзүүлэлтийн оноо, хэрэгжилтийн хувь /%/

д/д	Байгууллагын нэр	Шалгуур үзүүлэлтийн оноо				Хэрэгжилтийн хувь %
		МХБ	ХНБ	МБББ	ЭСТБ	
1	Цаг уур, орчны шинжилгээний газар	29	30	30	29	97
2	Ус цаг уур, орчны судалгаа мэдээллийн хүрээлэн	29	30	30	10	83
3	Байгаль орчин, хэмжил зүйн төв лаборатори	25	30	23	18	77
4	Нислэгийн цаг уурын төв	4	12	11	9	34

5	Улаанбаатар УЦУОШТ	20	30	18	20	79
6	Архангай УЦУОШТ	29	29	29	29	97
7	Баян-Өлгий УЦУОШТ	28	30	26	30	93
8	Баянхонгор УЦУОШТ	14	21	21	21	61
9	Булган УЦУОШТ	29	29	29	22	93
10	Говь-Алтай УЦУОШТ	26	30	27	26	89
11	Говьсүмбэр УЦУОШТ	29	30	29	30	99
12	Дархан-Уул УЦУОШТ	29	30	30	15	86
13	Дорноговь УЦУОШТ	29	30	28	29	95
14	Дорнод УЦУОШТ	14	26	14	14	61
15	Дундговь УЦУОШТ	29	30	30	30	99
16	Завхан УЦУОШТ	25	28	27	28	90
17	Орхон УЦУОШТ	29	29	28	29	96
18	Өвөрхангай УЦУОШТ	24	28	26	26	90
19	Өмнөговь УЦУОШТ					
20	Сүхбаатар УЦУОШТ	29	30	30	30	98
21	Сэлэнгэ УЦУОШТ	24	28	26	11	74
22	Төв УЦУОШТ	15	21	21	24	77
23	Увс УЦУОШТ	28	30	30	24	96
24	Ховд УЦУОШТ	30	30	30	30	99
25	Хөвсгөл УЦУОШТ	30	30	30	30	100
26	Хэнтий УЦУОШТ	14	25	9	9	48
	Салбарын дундаж	24	28	25	23	81

Тав. Дүгнэлт

1. Цаг уур, орчны шинжилгээний газрын “Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай” хуулийн хэрэгжилт 2025 оны 1 дүгээр улиралд 0%, 2 дугаар улиралд 73.6%, 3 дугаар улиралд 43.3%, 4 дүгээр улиралд 80%, 2025 оны 1 дүгээр улирал 97%-тай дүгнэгдсэн.

2. Ус цаг уур, орчны шинжилгээний салбарын байгууллагууд 2026 оны 1 дүгээр улиралд Нээлттэй мэдээллийн систем (www.shilen.gov.mn)-д мэдээ оруулан дундаж үнэлгээ 81%-тай гарсан. 2025 оны 1 дүгээр улиралд 10 байгууллага мэдээ оруулан дундаж үнэлгээ 28% байсан бол 2026 оны 1 дүгээр улиралд 25 байгууллага мэдээ оруулж үнэлгээ 81% болж өмнөх оны мөн үеэс 57%-ийн өсөлттэй байна.

4. Мэдээ, мэдээллийг системд оруулахдаа тухайн байгууллагат “Холбоо хамааралгүй” болох талаар үндэслэлтэй тайлбар бичиж оруулаагүй байдлаас болж “Нээлттэй байршуулаагүй” 0% үнэлгээг 8 байгууллага 19 удаа, Өмнөговь аймгийн УЦУОШТ мэдээ мэдээлэл илгээгүй 0% болж оноо доош буурсан.

4. Нээлттэй мэдээллийн систем, Төрийн байгууллагын цахим хуудас, байгууллагын цахим хуудаст мэдээ мэдээлэл оруулах албан тушаалтан томилсон ч томилогдсон албан тушаалтан мэдээллийн бүрдэл дутуу оруулах, хугацаандаа шинэчлээгүй, агуулгын хувьд тохирохгүй мэдээ оруулах, орсон мэдээллээ эргэж шалгахгүй байх, хугацаа хоцроох нийтлэг зөрчилтэй.

5. Нийт байгууллага мэдээллийн хүртээмжтэй байдал, тогтмол хугацаандаа мэдээллээ шинэчлээгүй, мэдээллийн бүрэн бүтэн байдал болон эх сурвалжийг журмын дагуу бичихгүй, дутуу хайнга хийж үнэлгээ хасагдах байдал ихэнх хувийг эзэлж байна.

Зургаа. Зөвлөмж

1. Нээлттэй мэдээллийн систем, Төрийн байгууллагын цахим хуудас, байгууллагын цахим хуудаст мэдээ мэдээлэл оруулах "байгууллагын админ", "байгууллагын бусад хэрэглэгч"-ийг тушаалаар томилон ажиллуулах; мэдээлэл оруулах ажилтны эрх, үүргийг тодорхой болгож, хариуцлагын тогтолцоог бүрдүүлэх, байгууллагын мэдээллийн ил тод байдлыг сайжруулах;
2. Мэдээллийн ил тод, нээлттэй байдлын мэдээллийг улирал бүр шинэчлэх, өөрчлөлт орсон даруй тухай бүр мэдээллийг тогтмол шинэчлэн оруулах, цахим хуудасны хандалтыг нэмэгдүүлэх, мэдээлэл хайх боломжийг хялбаршуулах;
3. Хуульд заасан мэдээллийн ангиллын дагуу нээлттэй мэдээллийг бүрэн оруулж, хяналтын жагсаалтаар шалгах;
4. Мэдээлэл хариуцагч нь байгууллага бүр тул мэдээллийн ил тод, нээлттэй байдлын 5 бүлэг, 87 нэр төрлийн мэдээнээс өөрийн байгууллагатаа хамаарал бүхий мэдээ мэдээллийг холбоос үзэх, файл үзэх, зураг үзэх гэсэн 3 хэлбэрээр оруулах, хамааралгүй мэдээллийг холбоо хамааралгүй болох тухай хуулийн заалт үндэслэл заавал бичих;
5. "Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай" хуулийн 8 дугаар зүйлийн 8.9-д заасны дагуу мэдээлэл хариуцагч хуулийн 8.2, 8.3, 8.4, 8.5, 8.6-д заасан тайлан, мэдээ, үр дүн, статистик мэдээллийг байгууллага тус бүр байгууллагын цахим хуудас, төрийн байгууллагын нэгдсэн цахим хуудас болон Нээлттэй мэдээллийн (shilen.gov.mn) системд тогтмол хугацаанд нь байршуулан 2026 оны 06 дугаар сарын 30-ны дотор 2 дугаар улирлын мэдээллийг шинэчлэн 100% бүрэн оруулж байгууллагын дотоод хяналтыг сайжруулах;
6. Нээлттэй мэдээллийн "shilen.gov.mn" системд 2026 оны 1 дүгээр улирлын мэдээг дутуу бүрэн бус хангалтгүй оруулж (Шилэн индекс)-ийн үнэлгээ 90 хувиас доош дүгнэгдсэн байгууллагуудад мэдэгдэл хүргүүлэх.

ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ
ГАЗРЫН ДАРГА



Э.БАТТУЛГА

2026 оны 05 дугаар сарын ...

ХЯНАСАН:
ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН
ХЭЛТСИЙН ДАРГА

Х.ОЮУНБИЛЭГ

2026 оны 05 дугаар сарын *21*

БОЛОВСРУУЛСАН:
ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН ХЭЛТСИЙН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

С.НАРАНЧИМЭГ

2026 оны 05 дугаар сарын ...*20*